БЭЙКЕР ТИЛЛИ
ДАЛАЙВАН АУДИТ
Аудит, баталгаажуулалт, үнэлгээ үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005402
Э.Шуудан: info@btdalaivanaudit.mn
Вэб хуудас: www.btdalaivanaudit.mn

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**“МОНГОЛ АЛТ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

## Санал дүгнэлт

Бид 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Монгол алт” ХК-ийн санхүүгийн тайланд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Монгол алт” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого, зардал, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартаар нийцүүлэн баталсан журам, заавар, аргачлалын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан.Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг“МНБ-ын ёс зүйн дүрэм”-г мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалтай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

## Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Гэхдээ бид энэхүү асуудлын талаар ямар нэг баталгаа илэрхийлэхгүй. Бидний гаргасан тайланд харилцахуйц хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

## Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй болно.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй болно.

**Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайлант бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Гэхдээ алдаанаас бус компанийн үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөхийг зориогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.

- ✓ Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.

- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад дотоод хяналтаас хэрэгжүүлж буй асуудлуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайланд харуулсан.

**Хэрэглээний хязгаарлалт**

Энэхүү тайланг Монгол улсын Компанийн тухай хуулийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Монгол алт" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

УЛААНБААТАР ХОТ

БЭЙКЕР ТИЛЛИ
ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

**2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР**

**МОНГОЛ АЛТ ХК**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

мянган төгрөг

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгөн хөрөнгө | 40,024.1 | 22,867.0 |
| Дансны авлага | 2,143,475.5 | 463,676.8 |
| Татвар, НДШ-н авлага | 296,827.3 | 61,237.2 |
| Бусад авлага | 215,560.1 | 16,952.5 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| Бараа материал | 72,533.2 | 30,946.4 |
| Урьдчилж төлсөн зардал /тооцоо | 1,816,247.0 | 1,784,659.5 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| *Эргэлтийн хөрөнгийн дүн* | *4,584,667.2* | *2,380,339.4* |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 1,159,008.8 | 979,195.2 |
| Биет бус хөрөнгө | 1,025.6 | 1,611.5 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 338,022.0 | 338,022.0 |
| Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | | |
| Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | 4,360,099.8 | |
| *Эргэлтийн бус хөрөнгийн дүн* | *5,858,156.2* | *1,318,828.7* |
| **Нийт хөрөнгийн дүн** | **10,442,823.4** | **3,699,168.1** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **Өр төлбөр** | | |
| Дансны өглөг | 6,273,660.9 | 34,804.1 |
| Цалингийн өглөг | 2,925.3 | |
| Татварын өр | 36,402.9 | 25,634.9 |
| НДШ-ийн өглөг | 8,701.8 | |
| Богино хугацаат зээл | 98,102.4 | 212,623.0 |
| Хүүгийн өглөг | | |
| Ногдол ашгийн өглөг | 107.6 | 107.6 |
| Урьдчилж орсон орлого | 2,281,569.5 | 2,144,292.5 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 966,613.1 | 574,946.1 |
| *Богино хугацаат өр төлбөрийн дүн* | *9,668,083.5* | *2,992,408.2* |
| Урт хугацаат зээл | | |
| Хойшлогдсон татварын өр | | |
| Бусад урт хугацаат өглөг | | |
| ***Урт хугацаат өр төлбөрийн дүн*** | | |
| ***Нийт өр төлбөрийн дүн*** | *9,668,083.5* | *2,992,408.2* |
| **Эздийн өмч** | | |
| Өмч: **Хувийн** | 26,585.2 | 26,585.2 |
| Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | | |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | |
| Хуримтлагдсан ашиг, алдагдал | 748,154.7 | 680,174.7 |
| *Эздийн өмчийн дүн* | *774,739.9* | *706,759.9* |
| **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | **10,442,823.4** | **3,699,168.1** |
| | - | - |

*Хавсаргасан тайлангууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

**МОНГОЛ АЛТ ХК**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

*мянган төгрөг*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|
| Борлуулалтын орлого | 1,436,955.0 | 329,770.0 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | (423,879.6) | |
| ***Нийт ашиг*** | ***1,013,075.4*** | ***329,770.0*** |
| Түрээсийн орлого | | |
| Хүүний орлого | 4,629.4 | |
| Ногдол ашгийн орлого | 38,653.5 | |
| Эрхийн шимтгэлийн орлого | | |
| Бусад орлого | | |
| Борлуулалт маркетингийн зардал | | |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 980,824.0 | *281,253.3* |
| Санхүүгийн зардал | | |
| Бусад зардал | 1.0 | 1,013.4 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| Бусад ашиг (алдагдал) | | |
| *Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал* | *75,533.3* | *47,503.3* |
| Орлогын татварын зардал | (7,553.3) | (4,750.3) |
| *Татварын дараах ашиг, алдагдал* | *67,980.0* | *42,753.0* |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг | | |
| **Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал** | **67,980.0** | **42,753.0** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | | |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| Бусад олз (гарз) | | |
| **Орлогын нийт дүн** | | |
| **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /төгрөг/** | | |

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

*Хавсаргасан тайлангууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

**МОНГОЛ АЛТ ХК**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*мянган төгрөг*

| ҮЗҮҮЛЭЛТ | Хувийн өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **26,585.2** | | | | | **637,421.7** | **664,006.9** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | - |
| **Залруулсан үлдэгдэл** | 26,585.2 | | - | | | 637,421.7 | **664,006.9** |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | | 42,753.0 | **42,753.0** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | | |
| Зарласан ногдол ашиг | | | | | | | |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | | |
| **2022 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл** | **26,585.2** | | - | | | **680,174.7** | **706,759.9** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | |
| **Залруулсан үлдэгдэл** | 26,585.2 | | - | | | 680,174.7 | **706,759.9** |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | | 67,980.0 | **67,980.0** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | | |
| Зарласан ногдол ашиг | | | | | | | |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | | |
| **2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл** | **26,585.2** | - | - | - | - | **748,154.7** | **774,739.9** |

*Хавсаргасан тайлангууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

**МОНГОЛ АЛТ ХК**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*мянган төгрөг*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|
| ***Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*** | | |
| *Мөнгөн орлогын дүн /+/* | *1,522,238.5* | *1,331,463.1* |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 1,056,018.8 | 505,251.7 |
| Эрхийн шимтгэл хураамж, төлбөрийн орлого | | |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 9,418.3 | 4,967.6 |
| Буцаан авсан албан татвар | | |
| Татаас, санхүүжилтийн орлого | 456,739.0 | 821,180.2 |
| Бусад мөнгөн орлого | 62.4 | 63.6 |
| *Мөнгөн зарлагын дүн /-/* | *(5,998,943.5)* | *(1,126,360.8)* |
| Ажиллагчдад төлсөн | 417,855.8 | 347,246.0 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 117,182.5 | 104,980.1 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 2,351,001.7 | 28,748.7 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 53,657.8 | 9,840.4 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 169,324.4 | 131,957.2 |
| Хүүний төлбөрт төлсөн | 207,907.3 | 47,201.1 |
| Татварын байгууллагад төлсөн | 68,210.2 | 52,653.2 |
| Даатгалын төлбөрт төлсөн | | |
| Бусад мөнгөн зарлага | 2,613,803.8 | 403,734.1 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(4,476,705.0)** | **205,102.3** |
| ***Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*** | | |
| *Мөнгөн орлогын дүн /+/* | *634,210.5* | *548,840.5* |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | 24,000.0 |
| Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | | |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 598,951.4 | 524,840.5 |
| Хүлээн авсан хүүний орлого | 4,567.0 | |
| Хүлээн авсан ногдол ашиг | 30,692.1 | |
| *Мөнгөн зарлагын дүн /-/* | *(2,553,032.9)* | *(813,629.6)* |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 39,152.9 | 65,712.1 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 2,513,880.0 | 747,917.5 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,918,822.4)** | **(264,789.1)** |
| ***Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*** | | |
| *Мөнгөн орлогын дүн /+/* | *7,607,215.2* | *296,453.0* |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 7,607,215.2 | 296,453.0 |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| Төрөл бүрийн хандив | | |
| Хөрөнгө оруулагчаас орж ирсэн санхүүжилт | | |
| Валютын ханшны тэгшитгэлийн ашиг | | |
| *Мөнгөн зарлагын дүн /-/* | *(1,194,530.7)* | *(221,671.4)* |
| Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 1,166,154.0 | 221,671.4 |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | | |
| Төлсөн ногдол ашиг | | |
| Бусад мөнгөн зарлага | | |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | |
| Валютын ханшны тэгшитгэлийн алдагдал | 28,376.7 | |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **6,412,684.5** | **74,781.6** |
| Валютын ханшны тэгшитгэлийн алдагдал | | |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **17,157.1** | **15,094.8** |
| *Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл* | *22,867.0* | *7,772.2* |
| *Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл* | *40,024.1* | *22,867.0* |

*Хавсаргасан тайлангууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING & APPRAISAL